МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.22 № 40

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД Т. МӨНХСАЙХАН ТАНАА

Монгол хүний эрүүл мэндийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 6 Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно гэсэн иргэний баталгаатай эдэлбэл зохих эрхийн хэрэгжилт. Энэ хүрээнд авч хэрэгжүүлсэн, бодлого, түүний хэрэгжилтийн үр дүнгийн талаар хийгдсэн хөндлөнгийн үнэлгээ, судалгаанд тулгуурласан товч мэдээлэл танилцуулга.
2. Улсын нэгдсэн төсвөөс сүүлийн 10 жилд эрүүл мэндийн салбарын хөгжилд зарцуулсан зарцуулалтын хэмжээ, эзлэх хувь, бүтэц, үр дүнд хийсэн шинжилгээний товч мэдээлэл,
3. Эрүүл Мэндийн Даатгалын Сангийн талаарх мэдээлэл.
4. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн агаарын чанарын үзүүлэлтүүд иргэдийн эрүүл мэнд, өвчлөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хийгдсэн судалгаа.
5. Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар хэрэгжүүлж буй бодлого, арга арга хэмжээний талаар товч танилцуулга.
6. Монгол Улсад баримталж буй эмийн стандарт нь олон улсын жишигт нийцэж байгаа эсэх?
7. Эрүүл мэндийн салбарт хэрэглэж буй эмийн чанарын үзүүлэлт болон өвчтөний эрүүл мэндэд үзүүлж буй эмийн сөрөг нөлөөллийн талаарх судалгаа, мэдээлэл, тавьж буй хяналтын үр нөлөөний талаар зохих танилцуулга.
8. Хөрс, усны бохирдол хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтэд нөлөөлж буй сөрөг нөлөө, энэ талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулга.

2024000963

9. Орчны бохирдол, доройтлоос улбаатай хүн амын өвчлөлийг бууруулах чиглэлээр баримталж ирсэн бодлого, салбар дундын зохицуулалт, уялдаа холбоо, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД

2024000063